



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар A/9

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалт, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Биеийн тамир, спортын судалгаа, шинжилгээ, туршилтын ажлыг санхүүжүүлэх журмыг нэгдүгээр, Эрдэм шинжилгээний оны шилдэг бүтээл сонгон шалгаруулах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Биеийн тамир, спортын судалгаа, шинжилгээ, туршилтын ажлыг санхүүжүүлэх, эрдэм шинжилгээний оны шилдэг бүтээл сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн газар /О.Гэрэл/, Спортын анагаах ухаан эрдэм шинжилгээний төв /Б.Эрдэнэваанчиг/-д тус тус үүрэг болгосугай.

3. Биеийн тамир, спортын судалгаа, шинжилгээ, туршилтын ажил, эрдэм шинжилгээний оны шилдэг бүтээлд олгох шагналын зардлыг жил бүрийн төсөвт тусган, санхүүжүүлж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Э.Адъяасүрэн/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /Ц.Одонбаяр/, Төрийн захиргааны удирдлагын газар /О.Баттулга/ нар тус тус үүрэг болгосугай.



142200111



Биэйн тамир, спортын улсын хорооны  
даргын 2022 оны 09 дугаар сарын 10 -ны  
өдрийн 10 тоот тушаалын нэгдүгээр  
хавсралт 10

## БИЕЙН ТАМИР, СПОРТЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТЫН АЖЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь судалгаа, шинжилгээ, туршилтын ажлыг хэрэгжүүлэх үндсэн зарчмыг тогтоох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Судалгаа, шинжилгээ, туршилтын ажил нь дараах төрөлтэй байна.

1.2.1 Суурь судалгааны төсөл

1.2.2 Захиалгат төсөл

1.2.3 Гадаадтай хамтарсан төсөл

1.3 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.3.1 “Суурь судалгааны төсөл” гэж хүн, нийгэм, хүрээлэн байгаа орчны хөгжлийн хүрээнд биэйн тамир, спортын талаар шинэ мэдлэг, мэдээллийг бий болгоход чиглэсэн судалгаа, шинжилгээ, туршилтын ажил;

1.3.2 “Захиалгат төсөл” гэж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ болон төрийн захирагааны байгууллагаас тодорхойлсон тулгамдсан асуудлыг судалж шийдвэрлэхэд чиглэсэн судалгаа, шинжилгээ, туршилтын ажил;

1.3.3 “Гадаадтай хамтарсан төсөл” гэж гадаад улс орон, олон улсын байгууллагатай хамтран ажиллах гэрээ (хэлэлцээр)-ний хүрээнд хэрэгжүүлэх 2 болон олон талт судалгаа, шинжилгээ, туршилтын ажил;

1.4 Судалгаа, шинжилгээ, туршилтын ажил хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах үе шаттай байна.

1.4.1 Захиалах, дэвшүүлэх, нээлттэй зарлах;

1.4.2 Боловсруулах, мэдүүлэх;

1.4.3 Сонгон шалгаруулах;

1.4.4 Гэрээ байгуулах;

1.4.5 Санхүүжүүлэх;

1.4.6 Хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд хяналт тавих;

1.4.7 Үр дүнг мэдээлэх, тайлагнах, баталгаажуулах;

- 1.4.8 Үр дүнг хүлээлгэн өгөх, санхүүгийн тооцоо хийх;
- 1.5 Төсөл хэрэгжүүлэхэд дор дурдсан үндсэн зарчмыг баримтална.
  - 1.5.1 Үр ашигтай байх;
  - 1.5.2 Тэгш өрсөлдөх боломжтой байх;
  - 1.5.3 Ил тод байх;
  - 1.5.4 Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын тэргүүлэх чиглэлд нийцсэн байх

#### **Хоёр. Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлыг санхүүжүүлэх**

- 2.1 Биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллага нь судалгаа, шинжилгээ, туршилтын ажлыг санхүүжүүлэх хөрөнгийн хувь хэмжээг Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн саналд үндэслэн тогтооно.
  - 2.1.1 Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын зардал нь дараах бүрдэлтэй байна.
  - 2.1.2 Судлаачдын цалин хөлс / нийт санхүүжилтийн 15 хувиас ихгүй байна./
  - 2.1.3 Судалгаа, шинжилгээ, туршилтад шаардагдах материал, хэрэглэгдэхүүн худалдан авах зардал / нийт санхүүжилтийн 25 хувиас ихгүй байна./
  - 2.1.4 Эрдэм шинжилгээний хурал, семинар, үзэсгэлэнгийн зардал
  - 2.1.5 Багаж, тоног төхөөрөмж, компьютер, сэлбэг хэрэгсэл, программ хангамж худалдан авах, суурилуулах, засвар үйлчилгээ хийлгэх зардал
  - 2.1.6 Эрдэм шинжилгээ, патентын мэдээллийн санд хандах болон архив, номын сангийн үйлчилгээний төлбөр
  - 2.1.7 Мэргэжлийн үнэлгээнд үндэслэн нийтэлдэг олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх төлбөр
  - 2.1.8 Судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой зардал
  - 2.1.9 Төслийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зардал
  - 2.1.10 Дээж шинжлүүлэх, хэвлэлийн эх бэлтгэл, хэвлэлт, орчуулга зэрэг бусдаар гүйцэтгүүлэх ажлын төлбөр
  - 2.1.11 Түрээсийн зардал /багаж, тоног төхөөрөмж/

2.2 Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын төрөл, шинж чанар, түүний үр дүнг ашиглах хүрээ, худалдан борлуулах боломж зэргийг харгалzan дараах хэлбэрээр санхүүжүүлнэ.

- 2.2.1 Буцалтгүй хэлбэрээр
- 2.2.2 Эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр
- 2.2.3 Зардлын тодорхой хувийг санхүүжүүлэх

2.3 Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлыг санхүүжүүлэх хэлбэрийг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тогтооно. Санхүүжилтийн хэмжээ, хугацаа, хэлбэрийг гэрээнд тодорхой тусгана.

2.4 Санхүүжүүлэх судалгаа, шинжилгээ, туршилтын ажлыг хүлээн авч, шийдвэрлэх цагалбар.

2.4.1 Санхүүжүүлэх судалгаа, шинжилгээ, туршилтын ажлыг өмнө оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс 3 дугаар сарын 15-ны өдрийн хугацаанд Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв хүлээн авна.

2.4.2 Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв нь хүлээн авсан судалгаа, шинжилгээ, туршилтын ажлыг 5 дугаарын сарын 10-ны өдрийн дотор салбарын эрдэмтдийн зөвлөлөөр хэлэлцүүлэн саналаа Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлнэ.

2.4.3 Биеийн тамир, спортын улсын хороо нь Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвөөс ирүүлсэн судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын саналыг 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дараа оны төлөвлөгөөнд тусган санхүүжилнэ.

2.5 Судалгаа, шинжилгээ, туршилтын ажил хэрэгжих явцад түүний санхүүжилтэд өөрчлөлт гарсан тохиолдолд Биеийн тамир, спортын улсын хороо /цаашид захиалагч гэх/, Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлыг хэрэгжүүлэгч /цаашид гүйцэтгэгч гэх/ талууд хамтран санал боловсруулж Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

2.6 Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын өртөг зардлыг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих асуудлыг энэхүү журмаар зохицуулна.

### **Гурав. Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавих**

3.1 Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын хэрэгжилтийн явц, хугацаа, үр дүн, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн байдал, санхүүгийн үйл ажиллагаанд Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв хяналт тавина.

3.2 Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын явц захиалагч, санхүүжүүлэгчээс үл хамаарах шалтгаанаар удаашрах, үр дүн нь гэрээнд заасан шаардлагыг хангагүй тохиолдолд захиалагч, санхүүжүүлэгч нь хугацаанаас өмнө гэрээг цуцлах, санхүүжүүлсэн хөрөнгийг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх талаар Биеийн тамир, спортын улсын хороонд санал тавьж шийдвэрлүүлнэ.

3.3 Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлыг сонгон шалгаруулах, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнтэй танилцахтай холбогдон гарах зардлыг Биеийн тамир, спортын улсын хороо хариуцна.

**Дөрөв. Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын үр дүнг хянах,  
баталгаажуулах, мэдээлэх, тайлагнах**

4.1 Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын үр дүн нь дор дурдсан хэлбэртэй байна.

4.1.1 Онолын судалгааны тайлан, онолын үндэслэл, үзэл баримтлал, загвар, нэг сэдэвт бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл;

4.1.2 Шинэ бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний загвар;

4.1.3 Шинэ технологи, технологийн заавар;

4.1.4 Техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, түүний эд анги, туршилтын загвар, ажлын зураг;

4.1.5 Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах техник-эдийн засгийн урьдчилсан судалгаа, үндэслэл, зураг, тооцоо;

4.2 Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын үр дүнг дор дурдсан баримт бичгүүдээр баталгаажуулна.

4.2.1 Мэргэжлийн хянан магадлагаанд үндэслэн нийтэлдэг гадаад, дотоодын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн нэг сэдэвт бүтээл;

4.2.2 Үндэсний болон олон улсын патент, патентын мэдүүлэг

4.2.3 Бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын гэрчилгээ;

4.2.4 Үндэсний болон олон улсын стандарт, норм, норматив;

4.2.5 Техник, технологийн баримт бичгийн иж бүрдэл;

4.2.6 Захиалагчийн дүгнэлт;

4.3. Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын гүйцэтгэлийг 2 хэлбэрээр тайлагнана.

4.3.1 Захиалсан үр дүн, санхүүжилтийн талаар зохих журмын дагуу бичсэн судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын тайланг захиалагч, санхүүжүүлэгчид тогтоосон хугацаанд хүлээлгэн өгнө.

4.3.2 Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын хүрээнд бий болсон шинжлэх ухааны мэдлэг /энэ журмын 4.2-т тусгагдсан баримтаар баталгаажсан/-ийн талаар улсын стандартын дагуу бичсэн судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын тайланг төсөл дууссанаас хойш 1 сарын дотор цахим болон хэвлэмэл хэлбэрээр гэрээ дүгнэсэн актаар хүлээлгэн өгнө.

**Тав. Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын  
санхүүгийн өр авлагыг барагдуулах**

5.1 Гэрээнд заасан шаардлагыг хангагүй гэсэн үндэслэлээр захиалагч төслийн эцсийн үр дүнг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд уг ажлыг дахин гүйцэтгүүлэх буюу санхүүжүүлсэн хөрөнгийг гүйцэтгэгчийг нөхөн төлүүлэх арга хэмжээг авна.

5.2 Судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын гүйцэтгэгч энэхүү журмын 4.3-д заасныг зөрчсөн тохиолдолд судалгаа, шинжилгээ, туршилтын ажлыг санхүүжүүлсэн хөрөнгийг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлнэ.

5.3 Судалгаа, шинжилгээ, туршилтын ажил хэрэгжүүлэхтэй холбогdon үүссэн маргааныг төрийн захиргааны байгууллага хүлээн авч шийдвэрлэнэ. Хэрэв гомдол гаргагч энэхүү шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд шүүхэд хандана.

---о0о---

Биеийн тамир, спортын улсын хорооны  
даргын 2022 оны 02 дугаар сарын 10 -ны  
өдрийн 11 тоот тушаалын хоёрдугаар  
хавсралт 19

## БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОНЫ ШИЛДЭГ БҮТЭЭЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь Биеийн тамир, спортын салбарт бүтээн туурвиж, практикт нэвтрүүлж, тодорхой үр дүн гарсан эрдэм шинжилгээ, судалгааны шилдэг бүтээлүүдийг өрсөлдүүлэх, шалгарсан бүтээлийг урамшуулах, түүнтэй холбогdon үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Эрдэм шинжилгээний оны шилдэг бүтээлд ганцаарчилсан болон хамтын бүтээлээр оролцож болно.

1.3 Жилд 1 удаа судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын тэргүүлэх чиглэлтэй нийцүүлэн оны шилдэг бүтээлийг шалгаруулж, шагнаж урамшуулна.

1.4 Эрдэм шинжилгээний оны шилдэг бүтээлийг салбарт үзүүлж буй ач холбогдол, практикт нэвтэрсэн байдал зэргийг үндэслэн шалгаруулна.

### Хоёр. Эрдэм шинжилгээний оны шилдэг бүтээлд дэвшүүлэх

2.1 Эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль, аж ахуйн нэгж, профессорын баг /эрдэмтдийн хамтлаг/, эрдэм шинжилгээний бүтээлээ оны шилдэг бүтээлд нэр дэвшүүлж болно.

2.2 Оны шилдэг эрдэм шинжилгээний бүтээлд зөвхөн сүүлийн 2-4 жилийн хугацаанд хийсэн бүтээлийг хамруулна.

2.3 Оны шилдэг бүтээлд нэр дэвшүүлэхдээ дараах материалыг бүрдүүлэн Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны дотор ирүүлнэ.

2.3.1 Оны шилдэг бүтээлд өрсөлдүүлэхээр нэр дэвшүүлж буй бүтээлийн танилцуулга;

2.3.2 Түүний зохиогчийн товч танилцуулга;

2.3.3 Бүтээлийн онол, практикийн ач холбогдлыг хэлэлцэн эрдэм шинжилгээний оны шилдэг бүтээлд дэвшүүлэхээр шийдвэрлэсэн эрдэм шинжилгээний байгууллагын эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэр;

2.3.4 Бүтээлийг үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын үнэлгээ, мэргэжлийн дүгнэлт буюу нэвтрүүлж ашиглах талаар хийсэн гэрээ, хэлцэл;

2.3.5 Шинэ бүтээлийн патент, ашигтай загварын гэрчилгээ зэрэг зохиогчийг гэрчлэх баримт байвал давуу тал болно;

## **Гурав. Шилдэг бүтээлийг шалгаруулах**

3.1 Биеийн тамир, спортын салбарын оны шилдэг эрдэм шинжилгээний бүтээлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах, сонгон шалгаруулах ажлын хэсгийг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар дараах бүрэлдэхүүнтэй байгуулна.

3.1.1 Биеийн тамир, спортын улсын хорооны төлөөлөл;

3.1.2 Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн төлөөлөл;

3.1.3 Салбарын эрдэмтдийн зөвлөлийн төлөөлөл;

3.1.4 Их, дээд сургуулийн төлөөлөл;

3.2 Бүтээлийг жил бүр Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвөөс зохион байгуулдаг эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлэн судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын тэргүүлэх чиглэлийн хүрээнд хийгдсэн байдлыг харгалзан үзэж сонгон шалгаруулна.

3.3 Оны шилдэг эрдэм шинжилгээний бүтээлийг сонгон шалгаруулах ажлын хэсэг нь үнэлгээний загвар болон хүснэгтийг хуралдаанаараа хэлэлцэн батална.

3.4 Оны шилдэг эрдэм шинжилгээний бүтээлийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байна. Сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүдийн 70% нь ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.5 Оны шилдэг бүтээлийг дараах үзүүлэлтээр шалгаруулна.

3.5.1 Бүтээлийн салбарт оруулж буй хувь нэмэр, ач холбогдол;

3.5.2 Тухайн бүтээлийг хэвлэн нийтлүүлсэн байдал;

3.5.3 Үйлдвэрлэл, үйлчилгээ, бусад салбарт нэвтрүүлэх боломж;

3.5.4 Практик хэрэглээ болгосон байдал, гарсан үр дүн.

3.5.5 Эдийн засгийн үр ашигтай байдал.

3.5.6 Инновац, шинэлэг байдал;

3.5.7 Олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлсэн байдал.

3.6 Оны шилдэг бүтээл сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүд тус бүр энэ журмын 3.5 дэх заалтад заасан үзүүлэлтүүдээр 3.3 дах заалтаар батлагдсан маягтын дагуу 1-5 онооны үнэлгээ өгнө.

3.7 Оны шилдэг бүтээл сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүдийн өгсөн оноог энэхүү журмын 3.3 дах заалтаар батлагдсан маягтын дагуу нэгтгэж, онооны нийлбэрээр хамгийн өндөр үнэлгээ авсан 3 хүртэлх бүтээлийг сонгон шалгаруулж болно.

**Дөрөв. Оны шилдэг эрдэм шинжилгээний бүтээлийг урамшуулах**

- 4.1 Эрдэм шинжилгээний оны шилдэг бүтээлийн шалгаруулалтын дүнг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын тушаалаар баталгаажуулна.
- 4.2 Шилдгээр шалгарсан бүтээлүүдэд тус бүр 5 сая төгрөгийн шагнал олгоно.
- 4.3 Эрдэм шинжилгээний оны шилдэг бүтээл шалгаруулах ажлын хэсгийн үйл ажиллагааны зардал болон оны шилдэг бүтээлд олгох өргөмжлөл, мөнгөн шагналыг Биеийн тамир, спортын улсын хорооноос санхүүжүүлнэ.

---оо---